



УЛААНБААТАР
ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН ХУРЛЫН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ТОГТООЛ

198 3 оны 1 дугаар

сарын 20 ны өдөр

Дугаар 15

Улаанбаатар

хот

БРИГАД БАЙГУУЛАХ ТУХАЙ

АХХ-3-ийн 1989 оны 161 дүгээр тогтоол

Улаанбаатар хотын АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас ТОГТООХ НЬ:

1. БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлийн 1965 оны 104 дүгээр тогтоол, Хөдөлмөр нийгэм хангамжийн улсын хорооны 1979 оны 19 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтыг үндэслэн Хот тохижуулах газрын харьяа Хот цэцэрлэгжүүлэх трестэд 12-р хорооллын паркийг хариуцсан арчлан хамгаалах бригадыг энэ оны 2-р сарын 1-нээс эхэлж байгуулсугай.

2. Зөвлөлтийн шинжлэх ухаан, соёлын ордны дэргэдэх паркийн мод, сөөг, зүлгийн ургацын болон арчилгаа, хамгаалалтын ажлыг шаардлагын хэмжээнд хүртэл сайжруулж тэдгээрийн орчны зам талбайг тогтмол цэвэрлэн гарсан хог хаягдлыг тухай бүр тээвэрлүүлж байхыг Хот цэцэрлэгжүүлэх трест /н.Гончоо/-д даалгасугай.

3. Паркийн арчлан хамгаалах бригадын орон тоо, цалингийн фондыг хянаж өгөхийг санхүүгийн хэлтэс /н.Эрдэмбат/-т даалгасугай.



УЛААНБААТАР ХОТЫН АРДЫН ДЕПУТАТУУДЫН
ХУРЛЫН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРГААНЫ

ДАРГА

[Signature]
С.МӨНХЖАРГАЛ

УЛААНБААТАР ХОТЫН АДХ-ЫН ГҮЙЦЭТГЭХ
ЗАХИРГААНЫ ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА

[Signature]
Ч.ЖАМБАЛ